Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 1.1. | Гүйцэтгэлийн зорилт №1.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах | - | - | - | 100 | | Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд боловсролын салбараас тусгуулах саналыг боловсруулан Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 1/179 дугаартай албан бичгээр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн Засгийн хөгжлийн сайдад хүргүүлсэн. Тус яамнаас 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төслийг Яамд, холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналуудад үндэслэж боловсруулж, Засгийн газрын хуралдаанд 2025.03.19-нд хэлэлцүүлсэн. Боловсролын сайдын 2025.04.22-ний өдрийн 1/1665 дугаартай албан бичгээр "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, "Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл", | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө", "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт"-д тусгах саналаа хүргүүлсэн. Төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний Төсвийн ерөнхийлөн захирагчийн 7 үр дүнгийн 7 шалгуур үзүүлэлт, хөтөлбөрийн 7 үр дүнгийн 18 шалгуур үзүүлэлтээр санал тусгасан. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-г хэлэлцэн баталсан.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.1.1 | Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд боловсролын салбарын асуудлаар тусгуулах санал боловсруулна. | - | Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгах саналын төсөл боловсруулалтын хувь | - | 100 | - | Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд боловсролын салбараас тусгуулах саналыг нэгтгэн боловсруулж Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 1/179 дугаартай албан бичгээр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн Засгийн хөгжлийн сайдад хүргүүлсэн. Тус яамнаас 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төслийг Яамд, холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналуудад үндэслэж боловсруулж, Засгийн газрын хуралдаанд 2025.03.19-нд хэлэлцүүлсэн. Боловсролын сайдын 2025.04.22-ний өдрийн 1/1665 дугаартай албан бичгээр "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, "Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл", "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө", "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хяналт- | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт"-д тусгах саналаа хүргүүлсэн. Төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний Төсвийн ерөнхийлөн захирагчийн 7 үр дүнгийн 7 шалгуур үзүүлэлт, хөтөлбөрийн 7 үр дүнгийн 18 шалгуур үзүүлэлтээр санал тусгасан. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-г хэлэлцэн баталсан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.2. | Гүйцэтгэлийн зорилт №1.2. Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах | - | - | - | - | | Тайлант хугацаанд 1)сайдын 2025.05.19-ны өдрийн А/229 дүгээр тушаалаар "Хос хэлний боловсрол, сургат зохион байгуулахад баримтлах чиглэл"-ийг анх удаа батлуулсан, 2) 2025.04.04-ний А/142 дугаар тушаалыг батлуулж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ажлын жишиг норм, нормативын төсөл боловсруулах ажлыг эхлүүлсэн, 3)цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэх саналыг боловсруулж, ГБХНЯ-д хүргүүлсэн, 4) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 31-д заасан багшийн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ зохион байгуулах шийдвэрийн төслийг боловсруулсан, 4) Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 14 мега төсөл, “Атрын IV аян”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал” зэрэг үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний | 70% | 70 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нөөцийг бэлтгэх төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлсэн, 5) "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын чанарын үнэлгээний журам"-ын төслийг боловсруулж, санал авах ажлыг эхлүүлсэн https://moe.gov.mn/post/166532, 6) Боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүйн дүрмийн төслийг эцэслэн боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлэн болгосон. Түүнчлэн тайланд хугацаанд 7) "Монгол хэл бичгийн шалгалт"-ын бэлтгэл хангах, зохион байгуулах сайдын 2025.03.25-ны өдрийн 02 дугаар албан даалгавар, "Боловсролын сургалтын байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах тухай " Боловсролын сайдын 03 дугаар албан даалгаврыг тус тус боловсруулж, батлуулав. 8) Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах, элсэлтийн болон монгол, хэл бичгийн шалгалт зохион байгуулах зардал батлах тухай шийдвэрийн төслүүдийг боловсруулж, батлуулсан<br>Хавсралт: 12 файл | | |
| 1.2.1 | Багшийн чадамжийн стандартын төсөл боловсруулна. | - | Төсөл боловсруулалтын хувь | 30 | 70 | 100 | Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/50 дугаар тушаалаар Багшийн чадамжийн стандарт боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Тайлант хугацаанд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд түшиглэн Багшийн чадамжийн хүрээ боловсруулах судалгааг эцэслэх, гадаад орнуудын | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | туршлага судлах, 21 дүгээр зууны багшийн чадамжийн хүрээний төслийг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж ажиллалаа. 2025.03.07-нд Багшийн чадамжийн стандарт боловсруулах ажлын явц, судалгааны үр дүнг нийслэлийн 1-р сургуулийн багш нартай хийсэн уулзалтын үеэр танилцуулан хэлэлцүүлсэн. Багшийн чадамжийн стандартын төслийг “Монгол Улсын үндэсний стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм” MNS 1-2:2022” стандартын бүтцэд оруулах ажлыг эхлүүлсэн. Стандартын төслийг шинэ багш, туршлагатай багш, мэргэшсэн багш, манлайлагч багш гэсэн 4 шаттай байхаар боловсруулж байна. Боловсролын сайдын 2025 оны А/25 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам"-д "2.3.Үндсэн сургалт нь багшийн чадамжийн стандартад заасан шаардлагад суурилсан 4 түвшин, удирдах ажилтны чадамжид суурилсан 3 түвшинтэй байна" гэж заасан бөгөөд багш 5 жил тутам багшийн чадамжийн стандартын түвшин ахиулах үндсэн сургалтад нийт 4 хүртэл удаа хамрагдахаар заасан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.2.2 | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны | - | Төсөл боловсруулалтын хувь | - | 30 | 100 | Боловсролын ерөнхий хуулийн "26.1.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 106.3-т заасны дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ажлын жишиг норм, нормативыг батлах" гэж Боловсролын асуудал эрхэлсэн | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлын норм, нормативын төсөл боловсруулна. | | | | | | Засгийн газрын бүрэн эрхэд хамаарахаар хуульчилсан. Өнөөдрийн хүртэл Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалала, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 дугаар тушаалаар батлагдсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох,багш албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам" хэрэгжиж байгаа. Тайлант хугацаанд энэ чиглэлээр хийгдсэн олон улсын болон дотоодын туршлага судлах судалгаа хийгдэж, норм норматив боловсруулах судалгааны арга зүйн төсөл боловсруулагдсан. 2025.05.08-ны өдөр Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ажлын жишиг норм, нормативын төсөл боловсруулах чиглэлээр Боловсролын яам, судлаачдын төлөөлөл оролцсон уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.<br>Хавсралт: 6 файл | | |
| 1.2.3 | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмыг шинэчлэн батлуулна. | - | Журамд нэмэлт оруулах төсөл боловсруулалтын хувь | 50 | 100 | - | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмын төсөлд оруулах өөрчлөлтийн саналын гол үзүүлэлт болох цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн туршилтын үр дүнг нэгтгэн саналаа ХНХЯ-нд /Засгийн газрын 5-р тогтоолд нэмэлт, өөрчлөлт / Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 1/992 дугаар албан бичгээр хүргүүлсэн. ХНХЯ-наас Засгийн газрын хуралдаанд уг тогтоолын өөрчлөлтийг хэлэлцүүлэхэд | 70% | 70 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бэлэн болсон. Хүргүүлсэн саналын дагуу "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмын төсөл"-ийг боловсруулан бэлэн болгосон.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.2.4 | Холбогдох байгууллагатай хамтран багшийн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийнэ | 300.00 | Судалгааны явц, хувь | - | 100 | - | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн “31.1.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг стандартын асуудал эрхэлсэн байгууллагын итгэмжлэл бүхий мэргэжлийн байгууллага батлагдсан журмын дагуу хийнэ”, “31.3.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/155 дугаар тушаалаар Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журмыг шинэчлэн баталсан. Монголын Боловсрол, Шинжлэх Ухааны Үйлдвэрчний Эвлэлийн Холбоотой байгуулсан 2024-2028 оны хамтын хэлэлцээрт “1.1 Боловсрол, шинжлэх ухааны салбарын хөгжлийн бодлогод нийцүүлэн баталсан хууль болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд боловсрол, шинжлэх ухааны салбарын багш ажилтны цалин хөлсний хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрийн норм, нормативтай холбоотой журам, дүрэм боловсруулах, хэлэлцүүлэх хэрэгжүүлэхэд хамтран зөвлөн тусалж, санал, зөвлөмж гаргаж хяналт тавина” гэж туссан бөгөөд 2025.02.27-нд уг хэлэлцээрт нэмэлт хэлэлцээр байгуулсан. Уг | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэлэлцээрийн “Гурав. Боловсролын салбарын ажилтны ажлын байрны үнэлгээг хийхэд хамтран судалгаа хийж, дүгнэлт гаргах” гэж туссан. Тайлант хугацаанд Боловсрол, Шинжлэх Ухааны Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны төлөөлөлтэй 2 удаагийн уулзалт зохион байгуулж, холбогдох журмын дагуу/https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960729483061/ үнэлгээ хийх хүрээ, шаардлагатай төсвийн саналууд боловсруулж, ажлыг 2025 оны III улиралд багтаан ажлыг гүйцэтгэхээр тохиролцсон. Боловсрол, Шинжлэх Ухааны Үйлдвэрчний Эвлэлээс ирүүлсэн саналыг тусган сайдын тушаалын төслийг боловсруулж удирдлагуудад танилцуулах ажлыг эхлүүлсэн. 2024-2025 онд боловсруулж, эцэслэсэн цэцэрлэгийн, 2023 онд батлагдсан ЕБС-ийн багшийн ажил, мэргэжлийн стандарт стандарт боловсруулах ажлын хүрээнд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ мөн хийгдсэн болно.<br>Хавсралт: 5 файл | | |
| 1.2.5 | Хос хэлний талаар баримтлах чиглэл боловсруулж батлуулна. | - | Батлуулсан чиглэл, тоогоор | - | 1 | - | Боловсролын сайдын 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн А/229 дүгээр тушаалаар “Хос хэлний боловсрол, сургалтын талаар баримтлах чиглэл”-ийг баталлаа. Энэхүү чиглэл батлагдсанаар казах, тува хүүхдэд эх хэлээрээ болон төрийн албан ёсны хэлээр чанартай, хүртээмжтэй боловсрол эзэмшиж, сурч хөгжих тогтолцоо бүрдэж байна.<br>Хавсралт: 1 файл | 100 % | 100 % |
| 1.2.6 | Мега төслүүдийг | - | 4 Мега төслийн | - | "Эрдэнэс инженер" | 4 Мега төслийн | Боловсролын сайдын 2025.04.18-ны өдрийн 1/1586 албан бичгээр яамд болон | 70% | 70 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх эд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх арга хэмжээ хэрэгжүүлнэ | | хүний нөөцийг бэлтгэх, сургах "Эрдэнэс инженер" арга хэмжээ | | арга хэмжээний төсөл боловсруулсан байна. | хүний нөөцийг бэлтгэх, сургах "Эрдэнэс инженер" арга хэмжээг Засгийн газарт хэлэлцүүлсэн байна | холбогдох төрийн өмчийн компаниудаас Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 14 мега төсөл, Монгол Улсын Ерөнхийлөгч санаачлан орон даяар өрнүүлж байгаа “Тэрбум мод”, “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал” зэрэг үндэсний хөтөлбөр, хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай инженер, техникийн болон мэргэжилтэй ажилтны судалгаа авч нэгтгэсэн. Энэ хүрээнд "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-аас Зэс боловсруулах үйлдвэрт 2028 оноос эхлэн 112 мэргэжлийн 870 мэргэжилтэй ажилтан шаардлагатайгаас 188 дээд боловсролтой мэргэжилтэн, 239 техникийн боловсролтой, 416 мэргэжлийн боловсролтой ажилтан шаардлагатай гэсэн судалгаа гарсан. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан мега төслүүд болон “Атарын IV” аян, “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжилтэй ажилтан, мэргэжилтэн бэлтгэх судалгаа хийх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Боловсролын сайдын 2025 оны "Зардал батлах тухай" А/201 дүгээр тушаалаар баталлаа.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.2.7 | Боловсролын үндэсний зөвлөлийн Ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлнэ. | - | Боловсролын үндэсний зөвлөлийн хуралдааны тоо | 1 | 1 | 1 | Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий хуулийн 23.3, 24.1.9-д заасан Боловсролын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилсэн. Тайлант хугацаанд Боловсролын үндэсний зөвлөлийн 2025 оны анхдугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тусгасан хуралдааны хөтөлбөрийн төслийг | 30% | 30 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулж, зөвлөлийн шинэчилсэн бүрэлдэхүүнтэй холбоотой мэдээллийг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн "Зардал батлах тухай" А/33 дугаар тушаалаар Боловсролын үндэсний зөвлөлийн хуралдаан зохион байгуулах болон ажлын албаны 2025 оны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг баталсан. Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн "2026 оныг "Боловсролыг дэмижх жил" болгон зарлах тухай" 158 дугаар тогтоолын 2-т "Боловсролыг дэмжих жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Засгийн газарт танилцуулахыг Боловсролын сайд, Боловсролын үндэсний зөвлөлд даалгасан. Үүнтэй холбоотойгоор Боловсролын үндэсний зөвлөлийн хуралдаан хүлээгдэж байгаа болно.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.2.8 | Гарааны багшийн чадамжийн хүрээг боловсруулна. | - | Төсөл боловсруулалтын хувь | 30 | 100 | - | Засгийн газрын 2024 оны 192 дугаар тогтоолоор батлагдсан “”Багшийн гурван тулгуурт бодлого” цогц арга хэмжээний “3.2.2.багшаар анхны жилдээ ажиллаж байгаа багшийн стандартыг тогтоож, багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөр, хувилбарт сургалтын хөтөлбөрт тусгах;” гэж заасан. 2024 онд Кембрижийн их сургуулийн зөвлөх багаас “Гарааны багшийн чадамжийн хүрээ”-ний төслийг боловсруулах чиглэлээр зөвлөх үйлчилгээ авсан. Энэ ажлын үр дүнд МУБИС “МУБИС-ийн гарааны багшийн чадамжийн хүрээ (стандарт)-г ректорын 2024 оны | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | А/349 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд Европын Холбооны Ерасмус хөтөлбөрийн хэрэгжүүлж буй "Монгол Улсын багш бэлтгэх хөтөлбөрийн ногоон болон дижитал шилжилт рүү шинэчлэн нэвтрүүлэх нь" (RETEACH) төслийн хэрэгжүүлж буй Отгонтэнгэр их сургуулийн төлөөлөлтэй 2025.04.17-нд уулзаж, төслийн хүрээнд боловсруулагдах саналыг гарааны багшийн чадамжийн хүрээнд тусгахаар болсон.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.2.9 | Боловсролын чанарын баталгаажуулалт хийх журам, аргачлалын төслийг боловсруулна. | - | Төсөл боловсруулалтын хувь | - | 30 | 100 | Боловсролын чанарын баталгаажуулалт хийхтэй холбоотой холбогдох материалуудыг уншиж судалж, журмын төслийн эхний хувилбарыг боловсруулж байна.<br>Хавсралт: 2 файл | 50% | 50 % |
| 1.2.10 | “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын чанарын үнэлгээний журам"-ыг батлуулна. | - | Журам боловсруулалтын хувь | 30 | 100 | - | Боловсролын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.3, 35.6 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.3, 26.4, 26.5, 27 дугаар зүйлийн 27.7 дахь заалтыг тус тус заасныг үндэслэн энэхүү журмын төслийг боловсруулан БЕГ, БҮТ, мэргэжлийн байгууллагуудаас санал авч байна. Дараах холбоосоор : https://moe.gov.mn/post/166532<br>Хавсралт: 1 файл | 70% | 70 % |
| 1.2.11 | Боловсролын сургалтын | - | Дүрмийн боловсруула | 50 | 100 | - | Боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүйн дүрмийн | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүйн дүрмийг батлуулна. | | лтын хувь | | | | төслийг эцэслэн боловсруулж Боловсролын сайдын тушаалаар батлуулахаар Хуулийн хэлтэст танилцууллаа. Хуулийн хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу ёс зүйн дүрэмд нэмэлт оруулав. Боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүйн дүрмийн төслийг Төрийн нарийн бичгийн даргын "Журам шинэчлэн батлах тухай" 2024 оны А/96 дугаар тушаалаар баталсан "Боловсролын яамны албан хэрэг хөтлөх журам"-ын дагуу Төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэсэн.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.2.13 | Боловсролын үндэсний үнэлгээ зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтыг хангана. | - | Гүйцэтгэлийн үнэлгээ, элсэлтийн шалгалт, сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ, чанарын үнэлгээ зохион байгуулахтай холбоотой сайдын тушаал, чиглэл, албан даалгавар | - | 70 | 100 | "Монгол хэл бичгийн шалгалт"-ын бэлтгэл хангах, зохион байгуулах тухай асуудлаар Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр 02 дугаар албан даалгаврыг боловсруулж, батлуулав. 2 . Боловсролын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.3, 35.4 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг 2025.04.28-05.03-ны өдрүүдэд, Ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн гүйцэтгэлийн үнэлгээ 2025.05.12-23-ны өдрүүдэд тус тус зохион байгуулахтай холбогдуулан "Боловсролын сургалтын байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах тухай " Боловсролын сайдын 03 дугаар албан даалгаврыг боловсруулж батлуулав. /2015.8 сая төгрөг/ 3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн байгууллагын үйл ажиллагааны болон | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулахад шаардагдах зардлыг /2,015,861,328 төгрөг/ Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/117 дугаар тушаалаар батлуулав. 4. "Монгол хэл бичгийн шалгалт"-ын бэлтгэл хангах, зохион байгуулах тухай Боловсролын сайдын 02 дугаар албан даалгаврыг боловсруулан, 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр батлуулав. 4. Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Журам батлах тухай” 2024 оны 115 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам”-ын дагуу СӨБ-ийн гүйцэтгэлийн үнэлгээ 2025 оны 4-р сарын 28-наас 5-р сарын 5-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 995 цэцэрлэг, 7290 багш, ЕБС-ийн гүйцэтгэлийн үнэлгээ 2025 оны 5-р сарын 12-23-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 700 сургууль, 29689 багш хамрагдлаа. 5. Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн "Элсэлтийн болон монгол, хэл бичгийн шалгалт зохион байгуулах зардал батлах тухай " А/102 дугаар тушаалаар / 1,427,0 сая төгрөг/ зардлыг батлуулав.<br>Хавсралт: 5 файл | | |
| 1.2. 14 | Монгол бичгийн цахим систем нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | - | GOOGLE хамтран монгол бичгийн цахим систем хөгжүүлэлтийн хувь | - | 40 | 60 | Төрийн албан хаагчдад зориулсан монгол бичиг сурах гар утасны аппликэйшнийг хөгжүүлэх ажлыг ВИЭСЭМ ТЕК ХХК гүйцэтгэсэн. “Үндэсний бичиг” мобайл аппликэйшн нь монгол бичигт суралцах, мэдлэгээ бататгах, шалгалт өгөх боломжийг бүрдүүлсэн аппликэйшн юм. Уг платформ нь цахим сургалтын дэвшилтэт | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шийдлийг ашиглан хэрэглэгчдэд онлайнаар болон сүлжээгүй орчинд ч үр дүнтэй суралцах боломжийг олгож байгаа. Монгол бичгийн анхан болон ахисан түвшний хичээлүүдийг YouTube видео болон PDF форматаар оруулж, суралцагчид өргөн сонголттойгоор хичээлээ үзэх боломжтой. Цагаан толгой: Үсэг тус бүрийн зурлага бүхий дэлгэрэнгүй танилцуулга, үндсэн ойлголтуудыг зураг хэлбэрээр багтаасан. Тулгуур ойлголт: Монгол бичгийн хичээлүүдийг зурган хэлбэрээр үзэх боломжтой. Сорил: 800 гаруй сорилыг агуулсан, хэрэглэгч тус бүрийн мэдлэгийг үнэлэх шалгалтын модуль. Үр дүнг бодитоор тооцон тайлагнах боломжтой. Хэрэглэгчийн бүртгэл ба статистик: Хэрэглэгч бүрийн сорилын гүйцэтгэл, нас, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэргийг ангилан харах дэвшилтэт шүүлтүүр бүхий тайлангийн хэсэгтэй. Вэб суурьт удирдлагын хэсэг нь PHP 8.3 болон Laravel framework дээр хөгжүүлэгдсэн. Админ нь хичээл, сорил, хэрэглэгчийн мэдээлэл болон аппликэйшний бүх контентийг хялбар удирдах боломжтой. Аппликейшн хөгжүүлэлт хийгдсэн: Мобайл хувилбар Flutter 3.32 хувилбар дээр шинэчлэн хөгжүүлэлт хийгдсэн. Android болон IOS бүх төхөөрөмжүүдийг дэмжиж ажиллахаар хийгдсэн байна. Мэдээлэл оруулах тест хийх ажлууд хийгдэн цагаан толгойн зурлага: 291, Тулгуур ойлголт: 100, Хичээл: 20, Сорил: 896 үндсэн мэдээлэл оруулсан байна. Сүлжээгүй орчинд ажиллах шийдэл нь нэлээдгүй бэрхшээлтэй байсан. Мөн Google PlayStore болон Apple AppStore байршуулах үед өмнөх ашиглаж байсан | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | түлхүүр үг байхгүй улмаас оруулах үед хугацаа алдаж байна. Удирдлага хэсэг шинээр хийгдэн аппликэйшн онлайн болон оффлайн ажиллах боломжтой болсон байгаа мөн хэрэглэгчээр бүртгүүлж сорилын үр дүнг харах, удирдлага хэсгээс мэдээлэл оруулахад хялбар бүрэн динамик болгон өөрчилсөн. | | |
| 1.2.16 | Боловсролын бодлого төлөвлөлтийн чиглэлээр орон нутгийн Боловсролын газрын хүний нөөцийн чадавхыг сайжруулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | - | Арга зүйн дэмжлэг үзүүлсэн Боловсролын газрын эзлэх хувь | - | 60 | 40 | Энэхүү арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан боловсролын салбарт хэрэгжүүлэх зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлт хийхэд дэмжлэг үзүүлж, 2025 оны төлөвлөлтөд тусгах талаар чиглэл өгсөн. 2.Английн Засгийн газрын санхүүгийн дэмжлэгээр НҮБ Хүүхдийн Сан, Боловсролын Яам хамтран хэрэгжүүлж буй "Алслагдсан орон нутгийн багш, сурагчдын англи хэлний ур чадварыг дэмжих нь" төслийн хүрээнд Өвөрхангай, Баянхонгор аймагт, 3. Бүсчилсэн хөгжил зөвлөлгөөнтэй уялдуулан Булган, Орхон аймагт, 4. Боловсролын сайд, ТНБД-аас өгсөн чиглэлийн дагуу Өмнөговь, Дархан-Уул аймгуудад томилолтоор ажиллаж, Боловсролын газрын дарга, албан хаагчидтай уулзалт зохион байгуулж, аймгийн боловсролыг хөгжүүлэх бодлого, төлөвлөлтийг хийх, газрын болон боловсролын сургалтын байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр санал солилцож, зөвлөмж өгч ажилласан. Аймгуудын Боловсролын газрын албан хаагч болон боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтнуудад боловсролын бодлого, төлөвлөлтийн | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, салбарын бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний талаар мэдээлэл өгсөн. Мөн аймгуудын Засаг даргын гэрээний хэрэгжилтийн явцтай танилцаж, орон нутгийн боловсролын бодлого, төлөвлөлт, хэрэгжилттэй танилцан, санал, зөвлөмж өгч ажиллалаа. Түүнчлэн аймгуудын Насан туршийн суралцахуйн төв, политехник коллеж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөгөө өгсөн. Дээрх ажлын хүрээнд аймгуудын Боловсролын газрын салбарын болон орон нутгийн боловсролын бодлого, төлөвлөлтийн уялдааг хангах, гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтод түвшинг тодорхойлох чадавхид ахиц гарсан. Мөн Боловсролын сайдын 2025.02.05-ны өдрийн "Аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн талаар авах арга хэмжээний тухай" А/48 дугаар тушаалыг батлуулж, хүргүүлсэн<br>Хавсралт: 7 файл | | |
| 1.3. | Гүйцэтгэлийн зорилт №1.3. Боловсролын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн | - | - | - | - | | 1. Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн "2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарлах тухай" 158 тогтоол батлагдсантай холбогдуулан "Боловсролыг дэмжих жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх боловсролын салбарт авч хэрэгжүүлэх шинэчлэлийн бодлого, арга хэмжээ, шаардлагатай хөрөнгө оруулалтыг тооцсны дараа Боловсролыг дэмжих түншлэгчдийн баг (LEG) -ийн уулзалтыг зохион байгуулахаар | 100 % | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төсөл боловсруулах, батлуулах, гадаад улс, олон улсын байгууллагаас санхүүжих төсөл боловсруулах, салбар хоорондын уялдааг бодлогын удирдамжаар хангах, боловсролын чанарын үнэлгээ болон насан туршдаа суралцахуйн тогтолцоог хөгжүүлж бүх түвшний боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах бодлогын чиглэл боловсруулах | | | | | хойшлогдсон болно. Хуралдаан зохион байгуулах чиглэлээр Японы элчин сайдын яамны холбогдох албан хаагчтай холбогдож ажилласан. 2. Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн "Төслийн удирдах хороо байгуулах тухай" А/88 дугаар тушаалаар Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагын “Системийн чадавхыг сайжруулах төсөл”-ийн Удирдах хороог, Төрийн нөрийн бичгийн даргын 2025оны 03 дугаар сарын 14-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/52 дугаар тушаалаар Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагын “Системийн чадавхыг сайжруулах төсөл”-ийн Мэдээллийн систем, статистик өгөгдлийг сайжруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсэг, Сургалтын орчны чанарын стандартыг боловсруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсэг, Хиймэл оюунд суурилсан багшийн виртуал туслахыг хөгжүүлэх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсэг, Дунд хугацааны төсвийн хүрээний дүн шинжилгээ хийх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсгийг тус тус байгууллаа. Ажлын хэсгийн хурлыг Дэлхийн банкны төлөөлөгчидтэй танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, төслийн хүрээнд хийгдэх ажлын чиглэл, олон улсын болон дотоодын зөвлөхийн ажлын даалгаварт тусгах санал солилцож, хүлээгдэж буй үр дүнг хэлэлцэж, Төслийн Удирдах хорооны хуралд танилцуулж, төслийн үйл ажиллагаа эхэллээ. 3. " Олон улсын "PISA-2025" үнэлгээний бэлтгэл хангах, зохион | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуула. 4. "АЛСЛАГДСАН ОРОН НУТГИЙН БАГШ, СУРАГЧДЫН АНГЛИ ХЭЛНИЙ УР ЧАДВАРЫГ ДЭМЖИХ НЬ” төсөл бүрэн хэрэгжсэн.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.3.1 | Боловсролын донор болон хөгжлийн байгууллагын хамтын ажиллагааны зохицуулалтыг хангана. | - | Боловсролыг дэмжигч түншлэгчдийн хуралдааны тоо | 2 | 1 | 1 | Монгол Улсын Засгийн газраас 2025 онй 04 дүгээр сарын 02-ны өдрийн "2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарлах тухай" 158 тогтоол батлагдсантай холбогдуулан "Боловсролыг дэмжих жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх боловсролын салбарт авч хэрэгжүүлэх шинэчлэлийн бодлого, арга хэмжээ, шаардлагатай хөрөнгө оруулалтыг тооцсны дараа Боловсролыг дэмжих түншлэгчдийн баг (LEG) -ийн уулзалтыг зохион байгуулахаар хойшлогдсон болно. Хуралдаан зохион байгуулах чиглэлээр Японы элчин сайдын яамны холбогдох албан хаагчтай холбогдож ажилласан. | 50% | 50 % |
| 1.3.3 | Боловсролын дэлхий нийтийн түншлэлийн “Системийн чадавх бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн төслийн 2 дахь шатны хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ. | - | Хэрэгжилтийн хувь | - | 30 | 70 | Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн "Төслийн удирдах хороо байгуулах тухай" А/88 дугаар тушаалаар Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагын “Системийн чадавхыг сайжруулах төсөл”-ийн Удирдах хороог, Төрийн нөрийн бичгийн даргын 2025оны 03 дугаар сарын 14-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/52 дугаар тушаалаар Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагын “Системийн чадавхыг сайжруулах төсөл”-ийн Мэдээллийн систем, статистик өгөгдлийг сайжруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсэг, Сургалтын орчны чанарын стандартыг | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсэг, Хиймэл оюунд суурилсан багшийн виртуал туслахыг хөгжүүлэх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсэг, Дунд хугацааны төсвийн хүрээний дүн шинжилгээ хийх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хэсгийг тус тус байгууллаа. Ажлын хэсгийн хурлыг Дэлхийн банкны төлөөлөгчидтэй танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, төслийн хүрээнд хийгдэх ажлын чиглэл, олон улсын болон дотоодын зөвлөхийн ажлын даалгаварт тусгах санал солилцож, хүлээгдэж буй үр дүнг хэлэлцэж, Төслийн Удирдах хорооны хуралд танилцуулж, төслийн үйл ажиллагаа эхэллээ. Хавсралт: 5 файл | | |
| 1.3.4 | Олон улсын сурлагын амжилтын судалгааг зохион байгуулах бэлтгэлийг хангаж, судалгааны ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана. | 767,500.00 | PISA-2025 үнэлгээний үндсэн судалгаанд хамрагдсан суралцагчийн хувь (192 сургуулийн 7450 суралцагч) ЭЗХХАБ-ын International Early Learning and Child Well-being Study-д хамрагдах талаар | - | 100 | 100 | 1. " Олон улсын "PISA-2025" үнэлгээний бэлтгэл хангах, зохион байгуулах тухай " Боловсролын сайдын 01 тоот албан даалгаврыг боловсруулж, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлуулав. 2. " Олон улсын суралцагчийн сурлагын амжилтын "PISA-2025" үнэлгээний үндсэн судалгаанд хамрагдах зардлын тооцоог хийж, тушаалын төслийг боловсруулж " Олон улсын суралцагчийн сурлагын амжилтын "PISA-2025" үнэлгээний үндсэн судалгаанд хамрагдах зардал батлах тухай " Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/38 дугаар тушаалаар батлуулав. 3. Олон улсын "PISA-2025" үнэлгээнд Орон нутгийн 100, нийслэлийн 91 сургуулийн 7450 сурагч түүвэрт сонгогдон хамрагдахаас 7142 | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хийгдсэн судалгаа | | | | сурагч (ирц 96%) хамрагдаж, мөн тооны эцэг эх, 1329 багш (ирц 96%) асуулгад хамрагдлаа.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.3.5 | "Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш нарын чадавхыг бэхжүүлэх" төслийн саналыг НҮБ-ийн Хүүхдийн Сантай хамтран боловсруулж, хэрэгжүүлнэ. | 860.00 | Хэрэгжилтийн хувь | - | 100 | - | Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын дэмжлэгээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сантай хамтран хэрэгжүүлэх "АЛСЛАГДСАН ОРОН НУТГИЙН БАГШ, СУРАГЧДЫН АНГЛИ ХЭЛНИЙ УР ЧАДВАРЫГ ДЭМЖИХ НЬ"-төслийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах ажлын хэсгийг Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 17-ний өдрийн А/105 дугаар тушаалаар байгуулж, Баян-Өлгий, Баянхонгор, Сүхбаатар аймагт амжилттай хэрэгжүүлж дууслаа. Төслийн хэрэгжилт, мониторинг хийх ажлыг 2025 оны 03 дугаар сарын 24-31-ний өдрүүдэд хийж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллалаа.<br>Хавсралт: 5 файл | 100 % | 100 % |
| 1.4. | Гүйцэтгэлийн зорилт №1.4. Дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай, монголын түүх, хэл, | - | - | - | - | | Засгийн газрын "Үзэл баримтлал батлах тухай" 2024 оны 176-р тогтоолоор батлуулсан “Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д “2.2.Монгол суралцагчийн эзэмших чадамж”-ийг суралцагчид эх хэл, бичиг үсэг, үндэсний болон дэлхийн өв соёл, биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдал, нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил хэмээн тодорхойлсон. Үзэл баримтлалд үндэслэн Боловсролын сайдын "Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2025 оны А/101-р тушаалаар "Сургуулийн өмнөх болон ерөнхий | 90% | 90 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний хөтөлбөрийг хөгжүүлнэ. | | | | | боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г шинэчлэн батлууллаа. Тушаалаар СӨБ болон бага боловсролын зөвхөн 1-2-р ангийн хөтөлбөрийг шинэчилж, 2025-2026 оны хичээлийн жилд улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. “Сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг 2025-2026 оны хичээлийн жилд улсын хэмжээнд хэрэгжүүлэх бэлтгэл хангах ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсэг"-ийг Боловсролын сайдын 2025 оны А/11-р тушаалаар батлуулан ажлын хэсэгт бодлогын дэмжлэг үзүүлж ажиллав. Мөн баталсан төлөвлөгөөний дагуу сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг дэмжих арга хэмжээ авахыг албан тушаалтанд үүрэг болгож Боловсролын сайдын 2025 оны А/60-р тушаал батлууллаа. СӨБ болон 1-2-р ангийн Би Монгол хүн сургалтын хөтөлбөрт Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжил олгох агуулгыг тусган шинэчлэв.Үүний дараа мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын хөтөлбөрт эдгээр агуулгыг залгамж холбоотой тусгахаар төлөвлөж байна.Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн төслийг 2025.05.28-ны өдөр Боловсролын сайд ахалсан СӨБ-ын Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлсэн. Тус зөвлөлөөс СӨБ-ын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн бодлогыг өөрчлөх болон бодлоготой холбоотой санал, зөвлөмж гараагүй. 1-2-р ангийн шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг Боловсролын сайд ахалсан Ерөнхий боловсролын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэсэн<br>Хавсралт: 7 файл | | |
| 1.4.1 | Бага, суурь боловсролын сургалтын хөтөлбөрт суралцагчдад дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвар эзэмшүүлэх агуулгыг тусган боловсруулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ. | 1,481.80 | Шинэчлэн боловсруулсан сургалтын хөтөлбөрөөр хичээллэж цахим, технологийн ур чадвар эзэмшиж буй ЕБС-ийн суралцагчийн тоо | 533 | 533 | 229,100 | Засгийн газрын "Үзэл баримтлал батлах тухай" 2024 оны 176-р тогтоолоор баталсан “Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д “СӨБ-д ...цахим технологийн энгийн төсөөлөл...”, “ЕБ-д технологи” суралцахуйн хүрээтэй байх, суралцагчдад компьютерын ухаан ба цахим технологийн чадамж эзэмшүүлэх гэсэн бодлого тусгагдсан. Үзэл баримтлалд үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Төлөвлөгөө, зардал батлах тухай" 2024 оны А/317-р тушаалаар “СӨБ болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах төлөвлөгөө”-г батлуулав. Үүний дагуу бага боловсролын сургалтын хөтөлбөрт дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэ нөхцөлд дасан зохицох улмаар даван туулах чадвар эзэмшүүлэх агуулгыг тусган шинэчилж эхэлсэн. БСҮХ-ийн захирлын “Санал хүргүүлэх тухай” 2025 оны 56-р албан бичгийн дагуу Боловсролын сайдын "Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2025 оны А/101-р тушаалаар "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г шинэчлэн батлууллаа. Тушаалаар бага боловсролын зөвхөн 1-2-р ангийн хөтөлбөрийг шинэчилж 2025-2026 оны хичээлийн жилээс улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр шийдсэн. “Сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын шинэчилсэн | 90% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтөлбөрийг 2025-2026 оны хичээлийн жилд улсын хэмжээнд хэрэгжүүлэх бэлтгэл хангах ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсэг"-ийг Боловсролын сайдын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2025 оны А/11-р тушаалаар батлуулж, тус ажлын хэсэгт бодлогын дэмжлэг үзүүлж ажиллав. Мөн баталсан төлөвлөгөөний дагуу сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг дэмжих арга хэмжээ авахыг албан тушаалтнуудад үүрэг болгосон Боловсролын сайдын "Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажилд дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх бэлтгэл хангах тухай" 2025 оны А/60-р тушаал батлууллаа. 1-2-р ангийн Компьютерийн ухаан сургалтын хөтөлбөрт кодчилол, роботик болон хиймэл оюуны ур чадвар, дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэ нөхцөлд дасан зохицох чадвар эзэмшүүлэх агуулгыг тусган шинэчиллээ.<br>Хавсралт: 7 файл | | |
